



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 87

Зуунмод

Г Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ,
байршил тогтоох тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээс ТОГТООХ нь:

1. Иргэдэд 2016 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт, түүний зураглалыг хавсралтын ёсоор баталж, Монгол Улсын Засгийн газарт уламжилсугай.

2.1 Энэ тогтоолын хавсралтад заасны дагуу иргэнд газар өмчлүүлэх ажлыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Баярбат/-д даалгасугай.

2.2 Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалт, зураглалыг тухайн сумын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах

2.3 Сэргэлэн сумын нутагт шинээр өмчлүүлэхээр төлөвлөгдсөн газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийж, өмчлүүлэх ажлыг Сэргэлэн, Зуунмод сумын газрын даамал, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтэнг оролцуулан хуулийн дагуу зохион байгуулах

2.4 Монгол Улсын иргэнд газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор сургалт сурталчилгааг эрчимтэй зохион байгуулж, сумдад ажиллах графикчилсан төлөвлөгөөг гарган мөрдөж ажиллах

2.5 Аж ахуйн зориулалтаар аймаг, сумын төв, суурин газарт эзэмшиж байсан газраа давуу эрхээр үнээр нь өмчлөх саналыг хот төлөвлөлтийн болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан "Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал"-ын дагуу үнийг тогтоон өмчлүүлэх

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Д.Батбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.МЭНДСАЙХАН

0100091

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын
22-ний өдрийн 87 тоот тогтоолын хавсралт.

Д/д	Сумын нэр	Өмчлүүлэх газрын байршил	Өмчлүүлэх газрын зориулалт /га-аар/			
			Иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-аар/	Үүнээс		Улсын чанартай замын дагуу өмчлүүлэх газар
				Одоо эзэмшиж, ашиглаж байгаа газрын нийт хэмжээ	Шинээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ	
1	Алтанбулаг	Сумын төв, суурин	231.0		231.0	
2	Аргалант	Сумын төв, авто замын дагуу	105.0			105
3	Архуст	Сумын төв, суурин	57.0		57.0	
4	Батсүмбэр	Сумын төв, суурин	81.8	26.8	55.0	
5	Баян	Сумын төв, авто замын дагуу	41.1	0.35	22.35	18.41
6	Баяндэлгэр	Сумын төв, авто замын дагуу	13.7	1.9	5.95	5.8
7	Баянжаргалан	Сумын төв	8.6	3	5.6	
8	Баян-Өнжүүл	Сумын төв, авто замын дагуу	5.2		5.00	0.21
9	Баянхангай	Сумын төв, суурин, авто замын дагуу	25.0	0.8	18.9	5.32
10	Баянцагаан	Сумын төв, авто замын дагуу	13.1	0.28	1.54	11.27
11	Баянцогт	Сумын төв	30.0	4	26.0	
12	Баянчандмань	Сумын төв, авто замын дагуу	27.5		27.50	
13	Борнуур	Сумын төв, авто замын дагуу	35.7	6.6	15.0	14.1
14	Бүрэн	Сумын төв	37.0	1.0	36.0	
15	Дэлгэрхаан	Сумын төв	11.6	10.0	1.6	
16	Жаргалант	Сумын төв, суурин	20.0		20.0	
17	Заамар	Сумын төв, суурин	105.5	1.72	103.8	
18	Зуунмод	Аймгийн төв	20.2	17.5	2.7	
19	Лүн	Сумын төв, авто замын дагуу	79.0	0.98	78	
20	Мөнгөнморьт	Сумын төв, суурин	130.0	15	115.0	
21	Өндөрширээт	Сумын төв, авто замын дагуу	12.1		9.7	2.38
22	Сэргэлэн	Сумын төв, суурин, авто замын дагуу	264.5	21	218.2	25.27
23	Сүмбэр	Сумын төв	26.5		3.0	23.5
24	Угтаал	Сумын төв, суурин	109.5	21.5	88	
25	Цээл	Сумын төв	192.0	16.0	176.0	
26	Эрдэнэ	Сумын төв, суурин, авто замын дагуу	360.8		360.8	
27	Эрдэнэсант	Сумын төв, авто замын дагуу	34.5		0.91	33.6
НИЙТ ДҮН			2077.9	148.4	1684.6	244.9